

## ТАНИЛЦУУЛГА

Ой модны сургалт, судалгааны хүрээлэн нь ХХААХҮЯам-ны захиалгаар “Монгол гэрийн мод. Ерөнхий техникийн шаардлага MNS 0370:2003”, “Монгол гэрийн дулаалгын бүрээс. Техникийн шаардлага MNS 5801:2007” стандартуудыг Монгол гэр, гэрийн иж бүрдэл үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоотой хамтран шинэчлэн боловсруулах ажлыг хийж гүйцэтгэв.

Энэхүү ажлын хүрээнд стандартуудад дараах зүйл, заалтуудыг нэмж, шинэчлэн боловсруулав. “Монгол гэрийн мод. Ерөнхий техникийн шаардлага MNS 0370:2003” стандартад шинээр оруулсан өөрчлөлтүүдийг 1-р хүснэгт, “Монгол гэрийн дулаалгын бүрээс. Техникийн шаардлага MNS 5801:2007” стандартад оруулсан өөрчлөлтүүдийг 2-р хүснэгтээр тус тус харуулав.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхимд энэхүү шинэчлэн боловсруулсан стандартын төслүүдийг тус тус хүргүүлж санал авсан болно.

### 1. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар:

- “Монгол гэрийн мод. Ерөнхий техникийн шаардлага” төслийн Нэр томъёо, тодорхойлолтонд заасан \* Унь .... шинэс, нарс гэсний дараа бургас гэж нэмэх.
- Стандартын төслийн 9.4 гэж шинээр нэмээд Гэрийн модыг тээвэрлэхдээ мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээтэйгээр тээвэрлэнэ гэж шинээр нэмэх.
- Монгол гэрийн дулаалгын бүрээс. Техникийн шаардлага MNS 5801:2007” стандартын төсөлд өгөх саналгүй болно.

### 2. Гаалийн ерөнхий газар:

- Уг стандартуудын төсөлд Гаалийн ерөнхий газрын зүгээс тусгайлан нэмэх санал байхгүй байна.

### 3. Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхим:

- “Монгол гэрийн мод. Ерөнхий техникийн шаардлага MNS 0370:2003, “Монгол гэрийн дулаалгын бүрээс. Техникийн шаардлага MNS 5801:2007” стандартуудын төслүүдтэй танилцаж МҮХАҮТ-ын веб сайт болон гишүүдын цахим шуудангаар дамжуулан бизнес эрхлэгчдэд мэдээлсэн болно. Уг стандартын төсөлд ямар нэгэн санал ирээгүй болно.

Дүгнэж хэлэхэд Гаалийн ерөнхий газар болон Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхимаас стандартуудын төсөлд нэмэх санал ирсэнгүй. МХЕГ-с ирүүлсэн “Стандартын төслийн 9.4 гэж шинээр нэмээд Гэрийн модыг тээвэрлэхдээ мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээтэйгээр тээвэрлэнэ гэж шинээр нэмэх” саналыг тээвэрлэх асуудлыг зохицуулсан санал байсан тул хүлээн аваагүй. Өөрөөр хэлбэл гарал үүслийн гэрчилгээг мод болон модон материалд олгодог харин гэрийн мод бол бүтээгдэхүүн учраас энэ саналыг тусгаагүй болно.

“Монгол гэрийн мод. Ерөнхий техникийн шаардлага MNS 0370:2003” стандартад  
шинээр оруулсан өөрчлөлт

1-р хүснэгт

<b>Стандартын хэсэг</b>	<b>Стандартын заалт</b>	<b>Шинээр нэмж тусгасан болон шинэчлэн найруулсан асуудал</b>
<b>Хамрах хүрээ</b>	1	Шинэчлэн найруулсан
<b>Норматив ишлэл</b>	2	Шинэчлэн найруулсан
<b>Нэр томъёо, тодорхойлолт</b>	3	27 ширхэг нэр томъёо шинээр нэмж оруулсан
<b>Ангилал</b>	4.1; 4.2; 4.3	Шинэчилсэн
	1-р хүснэгт	Гэрийн ялгаа бага, дунд, их гэдгийг гэрийн ханын тоогоор ялгасан
	4.4	Шинэчлэн найруулсан
<b>Техникийн шаардлага</b>	3-р хүснэгт	Ханын цонхны төмөр хэрэгсэл
<b>Гэрийн хана</b>	5.7.1; 5.7.2	Шинэчлэн найруулсан
	5.7.4; 5.7.5	Шинээр нэмж оруулсан
<b>Гэрийн багана</b>	5.8.1	Шинэчлэн найруулсан
<b>Гэрийн хаалга</b>	5.9.3	Шинэчлэн найруулсан
	5.9.4	Шинээр оруулсан
<b>Гэрийн шал</b>	5.10.1; 5.10.2	Тайлбар нэмсэн
<b>Гэрийн модны өнгөлгөө</b>	6.1; 6.2; 6.3; 6.4; 6.5; 6.6	Шинээр нэмж оруулсан
<b>Чанарыг шалгах арга</b>	7.6	Шинэчлэн найруулсан
<b>Хагалах, тээвэрлэх журам</b>	9.2	Шинэчлэн найруулсан
	9.4	Шинээр оруулсан

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код:

Монгол гэрийн мод. Ерөнхий техникийн шаардлага	MNS 0370 : 2020
Mongolian national ger. General technical requirements	MNS 0370 : 2003-ын оронд

СХЗГ-ын даргын ..... оны ..... дугаар сарын .... -ны өдрийн ... дугаар тушаалаар батлав.

Энэ стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдөнө.

## 1. Хамрах хүрээ

Монгол гэрийн модон хийцийн нэр төрөл, ангиллыг тогтоож, үндсэн хэмжээсийг тодорхойлоход хамаарна. Холбогдох ажлын зураг, загварыг боловсруулан батлуулах, үйлдвэрлэх, шалгаж хүлээж авах, гэрийн модыг иж бүрдүүлэх, хадгалахад уг стандартыг мөрдөнө.

## 2. Норматив ишлэл

Энэ стандартыг судалгааны материалд тулгуурлан шинэчлэн боловсруулахдаа өмнө мөрдөж байсан MNS 0370-2003 “Гэрийн мод. Техникийн шаардлага” улсын стандарт, “Монгол гэрийн сонгомол хэлбэрийг үүсгэгч тэг зураглал ба шугаман хэмжээ”, “Алтан огтлолын дүрэм” зохиогчийн эрх бүхий бүтээлийн утга санааг авч хэрэглэсэн болно.

Ишлэл татсан стандарт болон бусад бүтээлд өөрчлөлт оруулах болсон тохиолдолд түүний талаархи албан ёсны хамгийн сүүлчийн хэвлэлийг ашиглана.

## 3. Нэр томъёо, тодорхойлолт

### 3.1 Монгол гэр

Нутаг сэлгэн нүүдэллэхэд тохиромжтой, ачиж тээхэд хөнгөн, барьж буулгахад авсаархан конус маягийн хэлбэртэй монгол үндэсний орон сууц;

### 3.2 Монгол гэрийн мод

Тус бүрдээ тодорхой үүрэг гүйцэтгэдэг, барьж буулгахад хялбархан гэрийн бүрдэл, араг хийц хэсгүүд;

### 3.3 Багана

Гэрийн тооно өргөх, цөмийж орохоос хамгаалах, гэрийн тогтвор сайжруулах хос тулгуур;

### 3.4 Баганын далбаа

Гол тулгуурын хоёр тал ба тархийг холбосон гоёлтой хийц;

### 3.5 Баганын тархи

Гол тулгуур ба далбааг холбосон, мөөрний дагуу дугуйрсан буюу шулуун сээр;

### 3.6 Тооно

Гэрийн орой хэсэгт унины зэт шургаж холбогдох нүхтэй, тонолж хэлбэртэй хүрээ бүхий, агаар сэлгэх, гэрэл оруулах үүрэгтэй модон хийц. Тооно нь хорол, хүрд, сархигнаг хэлбэрт чонон голт тооно гэх мэт байна;

**3.7 Тоононы мөөр**

Цамхраа ба даага холбогдож байдаг гадна талын том хүрээ цагираг;

**3.8 Тоононы цамхраа**

Голд огтлолцдог хойд урд ба баруун зүүн, хагас дугуйрсан голууд;

**3.9 Тоононы даага**

Голуудын хооронд гадна ба дотно хүрээг холбодог хагас дугуйрсан туслах голууд;

**3.10 Хаалга**

Гэрийн үүдний хэсэгт дугуйлсан хатавчны ханын амсарыг бэхлэх, хүний гарч орох боломж хангадаг, үл хөдлөх жааз ба хөдөлгөөнт самбараас бүрдэх хийцийн хэсэглэл;

**3.11 Хаалганы самбар**

Нугасны тусламжтайгаар хаалганы хүрээний дотор нээгдэж хаагдах боломжтой, цоож, түгжээ ба дотно, гадна талдаа бариултай хавтас;

**3.12 Хаалганы босго**

Хүмүүсийн гарч ороход зориулагдсан, хаалганы доод хөндлөн яс мод;

**3.13 Хаалганы тотго**

Дээрээ унины бөгс тулах 4,6,8 хагас дугуйлан ухаж хонхойлсон нүхтэй, хаалганы дээд хөндлөн яс мод. Мөн ромбо тоогоор шинээр тааруулан зохиосон гэрт дэс дугаар тавьж өгнө;

**3.14 Унь**

Гэрийн дээврийн налууг бүрдүүлэгч нарийн шургааг хэлбэрийн хийц. Хэмжээ: Урт 2- 2,8 метр, голч 2–4 см. Шинэс, нарс, бургасаар хийдэг;

**3.15 Унины зэт**

Тоононы нүхэнд углах огтлогдсон пирамид хэлбэрийн унины чээжний төгсгөл хэсэг;

**3.16 Унины чээж**

Ихэвчлэн дөрвөн талтай огтлогдсон пирамид хэлбэрийн унины толгойн хэсэг;

**3.17 Унины сагалдарга**

Унины бөгсийг хананы толгойд өлгөх битүү гогцоо;

**3.18 Үдээр**

Гэрийн хана, тур мод үдэхэд голчлон хэрэглэдэг тэмээ, үхрийн ширээр зүсэж хийдэг нарийн сур;

**3.19 Үдээс**

Үдээрээр хана үдсэн хөдөлгөөнтэй холбоос;

**3.20 Хана**

Гэрийн жинг өөр дээрээ хүлээн авах, гэрийг гадна орчноос тусгаарлах үүрэг бүхий сараалжин хийцтэй, эвхэж хамхих, сунгаж тэлэх боломжтой, өвөрмөц зохиомж бүхий хийц;

### **3.21 Ханын толгой**

Унины сагалдарга мушгиж оруулах, хананы тур модыг хэлбэр гарган зассан оройн хэсэг;

### **3.22 Хананы тур мод**

Үдээсэн холбоосны тусламжтайгаар ханыг дэлгэх ба эвхэх боломж олгодог гүйцэд урттай тууш мод;

### **3.23 Ханын шийр**

Хананд ирэх даралтын бүх ачааллыг нэгэн жигд авч газар буюу шалан дээр тулах хананы доод босоо шулуун хэсэг;

### **3.24 Ханын эрс**

Хананы өөрчлөгддөг өндрийн хэмжээг илэрхийлэгч үзүүлэлт;

### **3.25 Хатавч**

Хана хаалга хоёрын нийлэх ам;

### **3.26 Хаяавч**

Гэрийн хаяагаар салхи, шороо тоос оруулахгүй байх, бас дулаалгын үүрэгтэй, 25-30 см-ийн урттай шинэсэн савх моднуудыг өргөнөөр нь хэлхэн, хүрээлсэн ханануудын нийт уртад тохируулан хийсэн, эвхэгддэг хаалт;

### **3.27 Шал**

Гэрийн дотор талын орчинг газраас тусгаарлах үүрэгтэй хавтгайлжин хийц; Ихэвчлэн шинэс, нарсаар хийдэг.

## **4. Ангилал**

### **4.1 Монгол гэрийг зориулалтаар:**

Ердийн сууцны гэр, Тусгай зориулалтын хэрэгцээний гэр гэж ангилна.

**4.2** Ердийн сууцны гэрийг ханын тоогоор нь 3-; 4-; 5-; их 5-; 6-; 8-; 10-; 12 ханатай гэж ангилна.

**4.3** Тусгай зориулалтын хэрэгцээний гэр нь дараахь төрөлтэй байна. Үүнд:

#### **4.3.1 Отрын гэр**

Дөрвөн цагийн эргэлтэнд мал аж ахуй эрхлэн нүүдэллэж явахад тохиромжтой ачиж тээвэрлэх, буулгах зөөж барихад хялбар (овор багатай бага дөрвөн ханат) гэрийг отор нүүдэлд голдуу хэрэглэнэ.

#### **4.3.1 Ёслол хүндэтгэлийн гэр**

Гэрийн хийцлэл, эд хэрэгсэл нь үндэсний уламжлалт өв соёл, ёс заншил түүхэнд тулгуурласан байх бөгөөд бэлэгдэлт хээ угалз, дүрс дүрслэлээр чимэглэн урласан байна. Томоохон хүлээн авалт зохион байгуулах, шагнал гардуулах зэрэг ёслол хүндэтгэл үзүүлэхэд зориулагдана.

**4.3.3 Аялал жуулчлалын гэр**

Монгол гэрийн уламжлалт хэв маягийг хадгалсан орчин үеийн хийцлэлтэй жуулчид, аялагчдын анхаарал сонирхолыг татахуйц гэрийг хэлнэ.

**4.3.4 Аяны жижиг эвхмэл гэр**

Эвхэгдэж дэлгэгддэг барьж буулгах ажлыг хялбар дөхөм болгосон, тээвэрлэхэд овор хэмжээ багатай богино хугацаанд гүйцэтгэх боломжтой, аян, рашаан ус, аялал зугаалга, амралтанд зориулагдсан гэрийг хэлнэ.

**4.3.5 Амралт, сувилалын гэр**

Төв суурин, амралт сувилалын газарт зориулан суурьшин амьдрах, тохилог тав тухтай байх, сувилуулах зориулалтаар монгол гэрийн хэв шинжийг хадгалсан монгол үндэсний архитектурын сонгодог хэлбэрийг, барилга байгууламжийн архитектуртай хослуулсан хийцлэл, бүтээцтэй гэрийг хэлнэ.

**4.3.6 Экспортын тусгай хэрэгцээний захиалгат гэр**

Гадаад улс орнуудын захиалгаар уламжлалт ердийн гэр сууцыг нийлүүлэх эсвэл тусгай хэрэгцээгээр захиалагчийн хүсэл сонирхол зориулалтаар урлаач, захиалагч нарын хоорондын саналын дагуу гүйцэтгэгдэнэ.

**4.4** Дээрх тусгай зориулалтын хэрэгцээний гэр нь энэхүү стандартаар тогтоосон ердийн сууцны гэрт тавигдах шаардлагуудыг хангасан байх ба зориулалт, захиалагч талын нэмэлт шаардлагыг, захиалагч ба нийлүүлэгч талууд зөвшилцөж, гэрээнд тусган үйлдвэрлэхийг зөвшөөрнө.

**4.5** Гэрийн модны үндсэн хэмжээ болон иж бүрдүүлэх хэсгийн тоо нь 1-р хүснэгтэнд заасантай тохирч байна.

Гэрийн модны үндсэн хэмжээ, иж бүрдүүлэх хэсэглэлийн тоо

1-р хүснэгт

Үндсэн хэмжээсүүд			Гэрийн хэмжээ, ханын тоогоор			
			3 ба 4	5	6≤	8≤
Тооно	Голч, см		/1250±5,5/	/1400±6,5/	/1500±6,5/	/1600±8/
Ханын тоо	Ханын толгойн тоонд	12	12		12≤	12≤
		15		15	15	
	Тур модны урт, см		1950	2100	2200≤	2200≤
Унины тоо	Ханын толгойн тоонд	12	52			102 ≤
		15	66	81	96≤	
	Урт, см		2000	2300	2450	2600≤
Баганын хэмжээ, см	Өндөр		2200	2350	2500	2550≤
	Тархины урт		800±10 (400)	900±10 (450)	1000- 1200≤	1000- 1200≤
	Хөндлөн огтлол		40x60	50x60	40x60≤	40x60≤
Шал	Голч, см		5300 ±20	6200±20	6600 ±20	6800 ≤

“ТАЙЛБАР”: 1. Хүснэгтэд заасан хэмжээ нь монгол гэрийг үйлдвэрлэлийн аргаар хийхэд хамаарах бөгөөд тусгайлан захиалгаар хийх тусгай зориулалтын хэрэгцээний ангиллын төрлүүдэд хамаарах гэрийн хэмжээг тусгаагүй.  
2. Хаалтан дотор байгаа тоо нь дүгрэг тархитай багана хийхэд хамаарна.

**4.6** Орон нутгийн орчин зүйн онцлог болон зан заншил, хэрэглээний өвөрмөц байдлыг харгалзан хэрэглэгчид үүнээс өөр хэмжээ сонгох, гэрийн модны эд ангийн хэлбэр, хийцэд зарим өөрчлөлт оруулахыг зөвшөөрнө.

**4.7** Үйлдвэрлэлийн аргаар хийх гэрийн модны хэсэглэл, тэдгээрийн зарим эд ангийн хэмжээ 2-р хүснэгтэд заасантай тохирч байна.

Гэрийн хийц хэсэглэлийн хэмжээ, мм-ээр

2-р хүснэгт

Эдлэл, эд ангийн нэр	Өндөр	Өргөн	Зузаан
Дөрвөн яс модтой хаалга	1450±10	1050±10	60 – 70
Зургаан яс модтой хаалга <sup>1</sup>	1480±10	1380±10	60 – 70
Хаалганы босго	100±5	1050±10 (урт)	60 – 70
Тоононы мөөр		80	70 – 80
Тооно, цамхраа /их, бага гол/	240 - 300	60 /их, бага гол/	45 /их, бага гол/
Хаяавч	/300-аас 360/±10	30-50/нэг модны/	15±5
Ханын цонх	1450±10	2 унь хоорондын зай буюу хананы алхам (450±10)	60 – 70

“ТАЙЛБАР”: 1. Зургаан яс модтой хаалгыг гэрийн үзэмж, хэлбэрийг төгс болгох үүднээс 5 ба 6-аас дээш тооны ханатай гэрт хэрэглэгчийн хүсэл сонирхолын дагуу хийж болно.

2. Түгээмэл хэрэгцээний 5 ханат болон 6 ханат гэрийн хаалганы өндөр тоононы диаметр тэнцүү хэмжээтэй байж болно.

Жишээ нь – 5 ханат гэрийн хаалганы өндөр, 1500 тоононы диаметр 1500

6 ханат гэрийн хаалганы өндөр, 1600 тоононы диаметр 1600

Гэр нь энэ хэмжээнээс хэт бага, хэт том хийгдэх тохиолдолд монгол гэрийн сонгомол хэлбэрийг үүсгэгч тэг зураглал ба шугаман хэмжээ, алтан огтлолын дүрэмийг авч

## 5. Техникийн шаардлага

**5.1** Гэрийн модны хэсэглэлийг энэ стандартын шаардлага, зохих журмаар технологийн заавар, ажлын зурагт заасан хэлбэр, хэмжээтэй хийнэ.

**5.2** Хийцийн модлогт байх согог 5-р хүснэгтэд зааснаас ихгүй байна.

**5.2.1** Хорхойн зам, давирхайн суваг зэрэг согогийг чигжиж тэгшилсэн байна.

**5.2.2** Гэрийн модны аль ч хэсэглэлд нэвт цууралт, унасан ярны нүх, өмх байж болохгүй.

**5.3** Гэрийн модны хийцийн хэсэглэл тус бүрийн эд ангиудыг сайтар эв нийлүүлж, улсын стандартын шаардлагыг хангасан, ус тэсвэрлэх чадвар сайтай, зориулалтын цавуугаар наасан байна. Эд ангийн цавуун холболтын бат бөх чанар нь 1 МПа- иас багагүй байна.

**5.4** Хаалга, тоонд бэхлэх төмөр тоноглолыг дараах хүснэгтэд заасан байдлаар гүйцэтгэнэ. Төмөр тоноглолын хурц ирмэг, өө сэвийг дарж зүлгэсэн, зэврэлтээс хамгаалсан бүрхэвчтэй байна.

Төмөр тоноглолын тоо, үндсэн хэмжээ

3-р хүснэгт

Үзүүлэлт	Гархи	Цүү	Хаалганы нугас	Хаалганы бариул
Тоо, ширхэг	12 (15)	12 (15)	2 (4)	2 (4)
Үндсэн хэмжээ /урт/, мм	30	50-60	70-100	100-120
Материалын төрөл	СТ-3	СТ-3	СТ-3	СТ-3
“ТАЙЛБАР”: Хаалтанд байгаа тоо нь ханын цонхны төмөр хэрэгсэл оруулсан тоо				

## 5.5 Гэрийн тооно

**5.5.1** Гэрийн тоононы хийцийг “Хоролт” маягаар хийх тохиолдолд түүнд тохируулсан дөрвөн ширхэг жаазыг иж бүрдүүлнэ.

**5.5.2** Тоононы мөөрний мод, гол цамхрааны залгаас, хаалганы яс модны холболтыг 8 мм-ээс 10 мм-ийн голчтой цавуутай модон шивхээр бэхэлсэн байна. Ажлын зурагт заасан хэмжээгээр нэг мөөрөнд бат бөх байхаар модон шивхээр холбоно. Модон шивхний чийглэг 6%-иас дээшгүй бөгөөд хатуу модлогоор хийсэн байна.

Тоононы их, бага голыг хоёр ширхэг, даагыг нэг ширхэг модон шивх ба шургаар бэхэлнэ. Цамхрааны даагыг мөөрөнд бэхлэхдээ 3-аас 5 мм-ийн голчтой 70-аас 80 мм-ийн урттай төмөр хадаасаар толгойг нь далд ортол шигтгэж хадсан байж болно.

**5.5.3** Тоононы цамхрааны 4 үзүүрт уях дааган чагтага, цамхрааны төвд уях гол чагтаганы гархи болон хаалганы хоёр талын шанаанд бэхлэх 6 гархи, тотгоны голд байрлах чагтаганы нэг гархийг бат бөх тогтоож, хаалганы нугас бариулыг буцаж сугарахгүй хийцтэй эргээр үзэмжтэй суулгаж бэхэлсэн байна.

**5.5.4** Тоононы мөөрөнд унины зэт шурган орох огтлогдсон пирамид хэлбэртэй нүхийг 1-р хүснэгтэд заасан унины тоотой ижил байхаар тооцож, эхний хоёр нүхийг урд гол, цамхрааны дундаас хоёр тийш тэнцүү зайтайгаар нүхэлсэн байна. Тоононы нүхний гадаргуу нь унины зэтний гадаргуутай шүргэлцэж байхаар, ажлын зурагт үзүүлсэн налуутай байна. Тоононы мөөрөнд гаргасан нүхний хэмжээ нь 4-р хүснэгтэд заасантай тохирч байх ёстой.

Тоононы мөөрөнд гаргах нүхний хэмжээ

4-р хүснэгт



Үзүүлэлт	Тоононы хэмжээ, мм				Зөвшөөрөгдөх зөрүү, мм
	1250	1400	1500	1600≤	
Зэт шургах нүхний амсрын хөндлөн огтлол	20x20	20x20	20x20	(25x25)≤	±0,1
Зэт шургах нүхний ероолын хөндлөн огтлол	19x19	19x19	19x19	(24x24)≤	±0,1
Уг нүхний гүн	25	25	25	30≤	±0,1
Унины үзүүрийн өргөн	18x18	18x18	18x18	(23x23)≤	±0,1

## 5.6 Гэрийн унь

**5.6.1** Унь нэг бүрийн бөгсөнд 15 см-ээс багагүй урттай томж нийтгэсэн эрч бүхий олс ба хялгасан сагалдаргыг 5 мм-ийн голчтой нүхэнд бат бөх уях бөгөөд 1,5 МПа-иас багагүй ачаалал дааж байх ёстой.

**5.6.2** Унины зэт 4-р хүснэгтэд заасан хэмжээтэй, огтлогдсон пирамид хэлбэртэй, тоононы мөөрийн нүхэнд налуу байрлан, эргэж холхихгүй тохирсон байна.

## 5.7 Гэрийн хана

**5.7.1** Монгол гэрийн хана нь дэлгэмэл хэлбэртэй, өвөрмөц онцлогтой учир ханын эрсийг өөрчилж болох бөгөөд ханын тур мод тус бүрийг ажлын зурагт заасан хэмжээгээр матаж, нүхэлж холбон үдсэн байдлаар тайлбарлагдана. Ханын тур модыг уламжлалт ба орчин үеийн арга технологиор матаж толгойн хэсгийг бага зэрэг гадагшаа налуутайгаар ( $2^0-5^0$ ), дунд бүслүүр хэсгийг гадагшаа алгуур гүдгэр байдлаар, шийрийн хэсгийг эгц босоо байдлаар үлдээж матмал хэлбэр бий болгодог. Хэрэв ханыг бургасаар хийсэн бол тур модыг гүйцэт зурвасласан байна. Ханын тур мод бүрийн толгойг мохоож зассан байхын зэрэгцээ бургасан ханыг үдэхдээ үзүүр талыг доош харуулсан байна.

**5.7.2** Ханын модыг ихэнхдээ зөв хадгалагдсан 3 мм-ээс доошгүй зузаантай тэмээний үдээр, заримдаа үхрийн ширийг 5 мм-ийн өргөнтэйгээр зүсэж, зай завсар гаргахгүй чанга үдсэн байна.

**5.7.3** Ханын модны зузаан 12 мм-ээс 15 мм, өргөн 30 мм-ээс 35 мм, бургасан ханын тур модны голч 17 мм-ээс 25 мм байна.

**5.7.4** Монгол гэрийн доторх гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, агааржуулалтыг сайжруулах, гэрээс гарахгүйгээр ойр орчмыг ажиглах, дотор талбайг нэмэгдүүлэх зорилгоор гэрийн хоёр ханын залгаас хооронд ханын цонх байрлуулж болно.

**5.7.5** Ханын цонхны босоо яс модны ханатай залгагдах талын хийц хаалганы шанаавчтай адилхан байна. Нэмэлт хэсэг тусгай хэрэгцээний төмөр болон модон араг хийцэн ханатай цонхтой гэрүүд нь гол төлөв диаметрээр хэмжигдэн захиалгын дагуу хийж байгаа учир, уламжлалт гэрийн хэмжээсээс өөр байж болно.

## 5.8 Гэрийн багана

**5.8.1** Гэрт хос багана хэрэглэх ба баганын тархи, далбааг хооронд нь углуурга заадлан холболтоор цавуудаж холбосон байна.

**5.8.2** Баганын тархи шулуун, нуман, далбаа нь гурвалжин, угалзан- хийцтэй байна. Баганын ишийг тэгш өнцөгт, квадрат, 6 талт призм хэлбэрийн хөндлөн, огтлолтой хийж, ирмэгийг ялимгүй дарж мөлийлгөсөн байна.

## **5.9 Гэрийн хаалга**

**5.9.1** Хаалганы тотгонд ажлын зургийн дагуу 4-өөс 6 ширхэг хоногийг, үүдэн хэсгийн унины голчийн 1/3 сууж байхаар хагас дугуйлан ухаж хонхойлсон байна.

**5.9.2** Хаалганы самбарын “толь” мод 8 мм-ээс 10 мм, хоёр талын шанаавч мод 25 мм-ээс багагүй тус тус зузаантай байна.

**5.9.3** Зургаан яс модтой, давхар хаалга ба ханын цонхыг захиалгаар үйлдвэрлэж нийлүүлнэ.

**5.9.4** Гэрийн хаалга ба ханын цонхны хоёр талын шанаан дээр таарах туурга ба бүрээсний амыг дарах 10 мм-ийн зузаан, 100 мм-ийн өргөн, 1450 мм-ийн өндөртэй даравч модыг гурван бүслүүрийн аман доор байрлуулна.

## **5.10 Гэрийн шал**

**5.10.1** Гэрийн шалыг бүрдүүлэгч хэсэг нь 10-аас цөөнгүй байх ба хэсэг бүрийн модыг тааруулсаны дараа баруун урд булангаас эхлэн араб тоогоор дугаарлан, ажлын зургийн дагуу дай модонд хадаж бэхлэх ба дай модыг чийг хорхойгоос хамгаалж түрхлэг түрхэж болно.

**5.10.2** Шалыг  $25\pm 0,5$  мм-ээс дээшгүй зузаантай шинэс,  $32\pm 0,5$  мм-ээс дээшгүй зузаантай нарсаар хийнэ. Шалны банзны өргөн 100-150 мм-ээс дээшгүй байна.

**5.10.3** Тухайн банзны ургалтын үеийн байрлал дахь гадна хацрыг дээш харуулан шалны гадаргууд ширхэгийн чиглэлийг харгалзан байрлуулна.

**5.10.4** Шалны банзыг өөр хооронд нь нягт шахаж, тус бүрийг дай модонд 3-аас 5 мм голчтой, 80-100 мм урттай төмөр хадаасаар хадаж, илүү гарсан үзүүрүүдийг эргүүлэн нугалж шигтгэсэн байна. Нэг дай модонд хадагдах хадаасны тоо 75 мм хүртэл өргөн банзанд нэг ширхэг, 75 мм-ээс 100 мм өргөн банзанд 2 ширхэг байна. Шалны бүрдэл хэсэг бүрт хадагдах дай модны тоог ажлын зурагт үзүүлсэн байх ба залгасан дай модны тоо нэгээс олонгүй байна.

**5.10.5** Шалыг зургаар жигд дугуйлан хөрөөдөх ба хаалганы талд ажлын зурагт заасан хэмжээтэй довжоо гаргасан байна.

## **5.11 Хаяавч**

**5.11.1** Хаяавч хийх мод шүргэдэстэй байж болох бөгөөд зузаан 10 мм-ээс 20 мм байна. Хаяавчны модны дээд, доод хэсэгт 4 мм-ээс 5 мм голчтой утсаар хэлхэх нүхийг 10 см зайтай хийнэ.

**5.11.2** Хаяавчны мод тус бүрийг 2 мм-ээс 3 мм-ийн голчтой, хоёроос цөөнгүй эгнээ төмөр утсаар хэлхэж холбох бөгөөд хэлхээний эх ба төгсгөлд нь ган утасны үзүүрийг хооронд нь холбож, хаалгатай бэхлэхэд зориулсан гогцоо гаргана.

## **6. Гэрийн модны өнгө, өнгөлгөө**

**6.1** Гэрийн мод нь сийлбэртэй, цоохорлож хээлсэн, цоолборлож лакадсан, цулгай суурьтай өнгө ялгасан гэх мэт захиалагчийн хүсэлтээр өргөн сонголттой хийж болно.

**6.2** Гэрийн тооно, унь ба хаалга нь цулгай болон хээлсэн өнгөлгөөтэй байж болно.

**6.3** Цулгай өнгөлгөө нь нэг ба хоёр өнгөтэй байна.

**6.4** Гэрийн модонд өнгөний зохилдлоготой, утга бэлгэдэлтэй, харагдах байдал гоо зүйтэй нутаг нутгийн ёс заншлаас хамааруулан тогтсон хэлбэр, агуулгатай хээ угалз тавихыг зөвшөөрнө.

**6.5** Тавих хээний дүрс, агуулгыг хэрэглэгчийн сонирхолд нийцүүлэн захиалгаар тавьж болно.

**6.6** Хээ тавихад зориулалтын багаж, хээ чимэглэлийн батлагдсан эх загвар, хэв шаблон, тусгай шаардлага хангасан байгалийн ба нийлэг гаралтай будаг хэрэглэнэ.

## **7. Чанарыг шалгах арга**

**7.1** Гэрийн модны бүрдэл хэсгийн чанарын хяналтыг эргономикийн, гоо зүйн үйлдвэрлэл дизайны, түүхий эд ашиглалтын гэсэн чиглэлээр хийнэ.

**7.2** Түүхий эд ашиглалтыг дамжлага дунд ба эцсийн боловсруулалтын үед шалгана.

**7.3** Гэр хийхэд хэрэглэгддэг модон түүхий эдийн чанар, түүнд байж болох согогийн хэмжээг 5-р хүснэгтээр үзүүлэв.

**7.4** Үндсэн хэмжээ болон согог, гэмтлийн хэмжээг тодорхойлохдоо 1 мм-ийн нарийвчлалтай шугам, шаблон, хязгаарлагч калибр хэрэглэнэ.

**7.5** Модны чийглэгийг MNS 2470:78, гадаргуугийн барзгарыг MNS 2386:77, холболтын бат бөх чанарыг MNS 2721:94, цавуун холболтын ус тэсвэрлэх чадварыг MNS 2722:79, модон эд ангийн үндсэн холбоосууд. Хэлбэр хэмжээ MNS 2447:87, будгийн хучилтын хатуулагийг MNS 2398:89, хийц хэсгийн найдвартай чанарыг зохих баримт бичгийн дагуу тогтоож шалгана.

**7.6** Гэрийн модны хэсэглэлийн гадаргуугийн барзгар, будгийн өнгө хослол, хээ чимэглэлийг батлагдсан эх загвартай харьцуулж тодорхойлохыг зөвшөөрнө. Будаг лак нь тогтоц сайтай гандалт удаан байгалийн гаралтай хүний биед сөрөг нөлөөгүй олон улсын стандартад хүлээн зөвшөөрөгдсөн байна.

**7.7** Хийцийн хэсэглэлд зайлшгүй байх металл эд ангийн гадаргуугийн барзгар, өнгөлгөө, цэвэрлэгээ, гагнаасыг батлагдсан эх загвартай харьцуулж шалгана.

## Гэрийн модонд байж болох согогийн хэмжээ

5-р хүснэгт

Согог	Тооно	Багана	Хана	Хаалга	Унь	Шал
А	1	2	3	4	5	6
1. Яр, ургалттай	мөөр, цамхрааны холбох хэсэгт байж болохгүй, мөөрний нэг нуманд 3- аас олонгүй байх	углуурга, заадлын хэсэгт байж болохгүй, бусад хэсэгт 15 мм хүртэл голчтой 3-аас олонгүй яр байж болно	үдэх нүхний хэсэгт огт байж болохгүй, бусад хэсэгт 5 мм хүртэл голчтой 3 - аас цөөн	оосорлох нүх, нугас, углуурга заадлын холбох хэсэгт байж болохгүй, бусад хэсэгт 25 мм хүртэл голчтой 3 - аас олонгүй	Сагалдарганы нүх ба зэтний орчимд байж болохгүй, бусад хэсэгт 5 мм хүртэл голчтой 3 - аас цөөн	Эв нийлэх, хадах хэсэгт байж болохгүй, бусад хэсэгт 25 мм -ээс ихгүй голчтой
2. Яр, ургалтгүй	мөөрний нэг нуманд 30 мм - ээс ихгүй голчтой 2 - оос цөөн	15 мм хүртэл голчтой яр 5- аас цөөн байна.	байж болохгүй	ярыг нэг төрлийн модоор ширхэг дагуу нөхсөн байж болно	15 мм -ээс бага голч бүхий 5 ш - ээс цөөн	Ширхэг дагууд ижилхэн модоор нөхсөн байна
3. Ан, цав	углуурга, уулзвар, нүхнээс бусад хэсэгт мөөрний нэг нуманд 20 мм-ээс бага урт, 3 мм- ээс бага гүн цав 1 ш	углуурга, заадлаас бусад хэсэгт 50 мм - ээс ихгүй урттай, 2 мм - ээс ихгүй өргөн, 3 мм-ээс ихгүй гүн цав 2 ш байж болно.	үдээрийн нүхнээс бусад газарт 50 мм- ээс бага урт, 2 мм-ээс их биш өргөн, зузааны 1/4- ээс ихгүй гүн цав 1 ш байж болно.	углуурга, заадлаас бусад хэсэгт 30 мм - ээс ихгүй урт, 2 мм-ээс ихгүй өргөн, зузааны 1/4- ээс ихгүй гүн цав 2 ш байж болно.	Байж болохгүй	Шалны банзны уртын 1/5 ээс ихгүй урт, зузааны 1/3 - ээс хэтрэхгүй гүн цав байж болно.

**7.8** Тоононы их, бага гол, даага, баганын иш, тархи, хана, унины модны ширхэг уртын дагуу тэнхлэгээс таших хазайлт 5 хувиас ихгүй байж болно.

## Боловсруулалтын шаардлага

6-р хүснэгт

Д/д	Үзүүлэлтүү Д	Бүтээцийн хэсэглэл					
		Тооно	Багана	Унь	Хаалга	Хана	Шал

1	Модны чийглэг, %	Наах модны эд ангиудынх 10>, харин матмал мөөрнийх чийг татах хязгаараас /28-30%/ багагүй	10>	10>	10>	Чийг татах хязгаараас /28-30%/ багагүй	15>
2	Гадаргуугийн байдал	цэвэршилт 8 - р	8 - р	8 - р	8 - р	8 - р	7 - р
3	Шүргэдэс	Байж болохгүй	байж болохгүй	байж болохгүй	Байж болохгүй	байж болохгүй	өнгөн талд байж болохгүй
4	Эд ангиудын хоорондох завсар	шилт жааз Даага мод хоёрын зай 3 - мм - ээс ихгүй			нээгдэж, хаагдах хэсэгт 2 мм - ээс ихгүй		шалны банз, хэсэглэлийн хооронд 3 мм - ээс ихгүй
5	Модлогийн сэнсрэлт, гажилт	Байж болохгүй	байж болохгүй	байж болохгүй	Диагоналын зөрүү 2 мм-ээс ихгүй	байж болохгүй	Байж болохгүй
6	Өнгөлгөөний байдал	Будалт жигд толигор, урсалтгүй	будаг жигд толигор, гялалзсан, урсалтгүй	будаг гялтгар, жигд толигор, урсалтгүй	будалт жигд толигор, урсалтгүй	зос, тосон будгийг жигд түрхсэн байж болно	будалт жигд
7	Өнгө будгийн хослол, хээ чимэглэл	эрүүл мэнд сэтгэл зүйд таатай байхуйц дулаан өнгөний хослол, гэрийн дотоод зайд хоршсон ая дан бүхий хээ чимэглэлийн цогц, иж бүрдэл				дулаахан нэг өнгөний дагнаас	

## 8. Савлах, хаяглах ажиллагаа

### 8.1

Гэрийн модны хийцийн хэсэглэлийг энэ стандартын дагуу шалган, хүлээн авч савлахдаа дараах тодруулгатай хаягийг наана. Үүнд:

- Үйлдвэрийн нэр;
- Гэрийн модны хийцийн төрөл (5 ханатын зүймэл тооног.м);

- Энэ стандартын дугаар (MNS ... : 2020);
- Бөөний ба жижиглэн худалдах үнэ;
- Хээ чимэглэлийн ангилал;
- Үйлдвэрлэсэн он, сар, өдөр чанар шалгаж баталгаажуулсан тэмдэг;

**8.2** Гэрийг үйлдвэрлэгчээс өөр газар бүрдүүлж байгаа бол дараах утгатай баримт бичгийг түүнд дагалдуулсан байна. Үүнд:

- Гэрийн модны хэсэглэл бүрийг хаана үйлдвэрлэсэн тухай тодорхойлолт;
- Гэрийн иж бүрдэлтийг гүйцэтгэж шалгасан шалгагчийн тэмдэг;
- Тухайн иж бүрдэлтэнд сагалдаргыг унины тоогоор, тоононы чагтага 5 ширхэг, боолтыг ханын тооноос нэгээр цөөн тоотой, дотуур бүслүүр нэг, дотор бүслүүрийн ульжаа 2 ширхэгийг дагалдуулна;

## 9. Хадгалах, тээвэрлэх журам

**9.1** Гэрийн модыг ус чийг, гал, механик гэмтэл, тоос шорооноос хамгаалсан агуулахад зориулалтын тавиур дээр иж бүрдэлээр нь ангилан хадгална.

**9.2** Унийг нэг гэрийн иж бүрдэл болох тоо хэмжээгээр нь хоёр хэсэг болгон баглаж, хайрцаглана.

**9.3** Гэрийн модыг механик гэмтэлд өртөхөөргүй, хээ чимэглэл, тоноглол гэмтэж эвдрэхээргүй жийрэглэн ачиж, ус чийг, тоос шорооноос хамгаалсан зориулалт бүхий татлага, бүтээлэгтэй бүх төрлийн тээврийн хэрэгслэлээр тээвэрлэнэ.

**9.4** Гэрийн иж бүрдэл тус бүрийг тоо хэмжээгээр нь тусгайлан авч үзэж овор ихтэй ачааг тээвэрлэх олон улсын стандартад нийцүүлэн хэсэг тус бүр болгон баглаж, хайрцаглана.

Жишээ нь овор ихтэй ачааг онгоцоор тээвэрлэх журам, олон улсын галт тэрэгний тээш чингэлгээр, машинаар тээвэрлэх гэх мэт.

## ТӨГСӨВ.

---

Хавсралт

---

### Гэрийн иж бүрдэлтэнд хамаарах нэмэлт заалт

Гэрийн унь, ханын мод болон төмөр тоноглолыг ширхэгээр худалдан авах боломжтойгоор үйлдвэрлэн, худалдаа болон гэр иж бүрдүүлэх газарт сэлбэг болгон ширхэгээр нийлүүлэхийг зөвшөөрнө.